

## ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН БА ТЭЭВЭР

### БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Уурхайн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэхийн зэрэгцээ орон нутгийн ард иргэдэд үр шимээ хүртээхүйц шинэ дэд бүтцийг барьж байгуулах
- Энэхүү дэд бүтцийн барилгын ажлын үе шатанд орон нутгийн ард иргэд болон зэрлэг амьтанд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилт тавих.

### ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

- Барилгын ажлын үе шатанд тоосжилт нэмэгдэж болзошгүй
- Замын хөдөлгөөний ачаалал нэмэгдсэнээр зэрлэг амьтан болон малын бэлчээр нутагт нөлөөлөл үзүүлэх
- Замын хөдөлгөөнтэй холбоотой аюул, ослын тохиолдол нэмэгдэх боломжтой
- Барилгын ажил, ашиглалтын үйл ажиллагаа болон уурхайн татан буулгалт зэрэг төсөлтэй холбоотой аюул.

### БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

Бид өөрсдийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд доорхи зүйлсийг хийж гүйцэтгэсэн болон хийж байна:

ЗАМ: Бүс нутгийн замыг сайжруулах:

- Зэсийн баяжмалыг хилийн боомт хүргэх зориулалт бүхий Оюу Толгой – Гашуун Сухайтын замыг Монгол Улсын хатуу хучилттай замын стандартад нийцүүлэн сайжруулах





- Замын тэмдэг тэмдэглэгээ, жолооч нарын сургалт болон олон нийттэй хийх хэлэлцүүлэг зэргээр зэрлэг амьтан хамгаалах зорилготой, нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Оюу Толгойгоос Ханбогд сумын төв хүртэлх замыг сайжруулах, арчилгаа хийх
- Шинээр баригдах нисэх буудал руу хатуу хучилттай зам тавих (Уурхайн талбайгаас хойд зүгт 7 км).

#### НИСЭХ БУУДАЛ:

- Олон улсын стандартад нийцсэн бүрэн хэмжээний нисэх буудлыг барьж байгуулах.

#### БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ:

- Зам болон нисэх буудлын барилгын ажлаас үзүүлэх нөлөөллийг хянах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх:
  - Замыг хатуу хучилттай болгох, хурд хязгаарлах зэргээр авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй тоосжилтыг хянах
  - Хурдны дээд хязгаарыг тогтоох, зөвхөн заагдсан чиглэлээр зорчих, мал, амьтан замд ойр байх үеийн тээврийн хэрэгсэл жолоодох дүрэм журмыг гаргах зэргээр хүн, мал, амьтан зам тээврийн осолд өртөх эрсдлийг бууруулах.

#### ОРОН НУТГИЙН АРД ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

- Орон нутгийн ард иргэд болон тээврийн хангамжийн замын дагуу бүсэд бүрэн хэмжээний Замын хөдөлгөөний мэдлэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Ханбогд сумыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах зэрэг онцгой байдал болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт хийх.



Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан Тээврийн менежментийн төлөвлөгөө болон Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г [www.ot.mn](http://www.ot.mn) цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.